



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХЭРГИЙН ЯАМ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 7а, Утас: 26 21 35,
Факс: (976-11) 32 21 27, E-mail: info@mfa.gov.mn,
http://www.mfa.gov.mn

2015. 09. 29 № 09/5236
танай _____-ны № _____-т

ИРГЭНИЙ ХАРЬАЛАЛ, ШИЛЖИЛТ
ХӨДӨЛГӨӨНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД
ДАРГА Л.БААТАРЧУЛУУН ТАНАА

Бразилиа хотноо 2015 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр гарын үсэг зурсан "Богино хугацааны визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр" нь 2015 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчлэх болсныг үүгээр мэдэгдэж байна.

Хэлэлцээрийн хуулбарыг танай ажлын хэрэгцээнд зориулан үүгээр хүргүүлэв. Холбогдох газартаа уламжилна уу.

Хавсралт: 11 хуудас.

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН
ГАЗРЫН ЗАХИРАЛ



А.ТӨМӨР

812463



EMBASSY OF MONGOLIA
BRASILIA

Хүндэт эрхэм ээ,

Таны дараахь агуулга бүхий 2015 оны 9 дүгээр сарын 24-ний ноот бичгийг хүлээн авснаа мэдэгдэх завшаан тохиолдов:

"Хүндэт эрхэм ээ,

Манай хоёр орны хоорондын найрсаг, ойр дотно харилцааг бататган бэхжүүлж, улам бүр хөгжүүлэх, түүнчлэн харилцан адил байх зарчмыг бататган хоёр улсын иргэд зорчих нөхцөлийг хөнгөвчлөх зорилгоор Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын Засгийн газар харилцан адил байх зарчмын үндсэн дээр иргэдийг богино хугацааны визийн шаардлагаас чөлөөлөх чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэх болсныг Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс Танд уламжлахад таатай байна:

1. Хүчин төгөлдөр зорчих бичиг баримт бүхий Монгол Улсын иргэд албан хэргээр болон аялж жуулчлах зорилгоор Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсад нэг жилийн хугацаанд 90 (ер) хоногоос хэтрэхгүй хугацаанд визгүйгээр орох, гарах, дамжин өнгөрөх болон зорчих эрхтэй ба уг хугацааг Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын нутаг дэвсгэрт анхлан нэвтрэн орсон өдрөөс эхлэн тооцно. Энэхүү 90 (ер) хоногийн хугацааг Бразил Улсын холбогдох эрх бүхий байгууллагаас нэг удаа 90 (ер) хоногоос хэтрэхгүй хугацаагаар сунгаж болно.

2. Энэхүү ноот бичигт заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор:

(1) аялж жуулчлах гэж Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын нутаг дэвсгэрт санхүүгийн үүрэг хариуцлага хүлээхэд хүргэж болох ямар нэг ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахгүйгээр амрах, танилцах, соёлын болон бусад зорилгоор зорчихыг хэлнэ.

(2) дамжин өнгөрөх гэж Монгол Улсын иргэд зорчих сүүлчийн газартаа очихын тулд Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын нутаг дэвсгэрт нэвтрэн орох шаардлагатай болохыг хэлнэ.

(3) албан хэргээр зорчих гэж Монгол Улсын иргэд Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахгүйгээр арилжаа эрхлэх боломж бололцоог судлах, уулзалт, хуралд оролцох, гэрээ байгуулах, менежментийн болон захиргааны үйл ажиллагаа явуулах зорилгоор зорчихыг хэлнэ.

3. Монгол Улсын иргэд Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын нутаг дэвсгэрт 90-ээс дээш хоногийн хугацаанд зорчих, ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах, хөдөлмөр эрхлэх, судалгаа, сургалтад оролцох, сурах, нийгмийн үйл ажиллагаанд оролцох, түүнчлэн техникийн туслалцаа үзүүлэх, томилолтоор ажиллах, шашны, эсхүл урлагийн үйл ажиллагаанд оролцох, эсхүл энэхүү ноот бичгийн 2 дахь заалтад тодорхой зааснаас бусад аливаа үйл ажиллагаа явуулах тохиолдолд Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын хууль тогтоомжийн дагуу зохих визийг урьдчилан мэдүүлэх ёстой.

4. Энэхүү ноот бичгийн 1 дэх заалтад дурдсан Монгол Улсын иргэд Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын олон улсын зорчих хөдөлгөөнд нээлттэй хилийн шалган нэвтрүүлэх цэгээр дамжин тус улсад нэвтрэн орох, дамжин өнгөрөх болон гарах эрхтэй.

5. Үүгээр олгосон визээс чөлөөлөх арга хэмжээ нь Монгол Улсын иргэдийн Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсад богино хугацаагаар зорчихдоо тус улсад хүчин төгөлдөр үйлчилж буй үндэсний хууль тогтоомжийн дагуу хүлээх үүргийг хөндөхгүй.

6. Үүгээр олгосон визээс чөлөөлөх арга хэмжээ нь Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын Засгийн газрын Монгол Улсын тааламжгүй иргэдийг өөрийн нутаг дэвсгэрт оруулахаас татгалзах болон зорчих хугацааг багасгах эрхийг хөндөхгүй.

7. Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын Засгийн газар үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах, эсхүл олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор энэхүү ноот бичигт тодорхойлсон арга хэмжээг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь зогсоож болно. Энэхүү арга хэмжээг зогсоох тухай шийдвэрийг Монгол Улсын Засгийн газарт дипломат шугамаар нэн даруй мэдэгдэнэ.

8. Монгол Улсын иргэд Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын нутаг дэвсгэрт зорчих хугацаандаа зорчих бичиг баримтаа гэж үрэгдүүлсэн тохиолдолд Бразил Улсад байгаа Монгол Улсын дипломат буюу консулын төлөөлөгчийн газраас өөр зорчих бичиг баримт авч тус улсын нутаг дэвсгэрээс гарна.

9. (1) Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын Засгийн газар энэхүү ноот бичгийг солилцсон өдрөөс хойш 30 (гуч) хоногийн дотор Монгол Улсын Засгийн газарт өөрийн паспортын загварыг өгнө.

(2) Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын Засгийн газар өөрийн олгодог паспортод өөрчлөлт оруулсан тохиолдолд түүнийг ашиглаж эхлэхээс дор хаяж 30 (гуч) хоногийн өмнө шинэ паспортын загварыг түүнийг хэрхэн хэрэглэх тухай танилцуулгын хамт Монгол Улсын Засгийн газарт хүргүүлнэ.

10. (1) Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар харилцан тохиролцож энэхүү ноот бичгийн агуулгад өөрчлөлт оруулж болох бөгөөд үүнийг дипломат шугамаар баталгаажуулж мэдэгдэнэ. Талууд өөрөөр тохиролцоогүй бол нэмэлт, өөрчлөлт нь энэхүү ноот бичгийн 11(1)-д заасны дагуу хүчин төгөлдөр болно.

(2). Энэхүү ноот бичигт тодорхойлсон арга хэмжээг тайлбарлах, эсхүл хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Талуудын хооронд үүссэн маргааныг дипломат шугамаар зөвлөлдөх болон хэлэлцээ хийх замаар шийдвэрлэнэ.

11. (1) Энэхүү ноот бичигт заасан арга хэмжээ нь уг ноот бичгийг солилцсон өдрөөс хойш 30 (гуч) хоногийн дараа хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.

(2) Энэхүү ноот бичигт тодорхойлсон арга хэмжээг хугацаагүйгээр хэрэгжүүлэх бөгөөд Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын Засгийн газар Монгол Улсын Засгийн газарт дипломат шугамаар бичгээр мэдэгдэх замаар тэдгээрийг хэдийд ч цуцалж болно. Үүгээр бий болгосон арга хэмжээ нь тэрхүү мэдэгдлийг хүргүүлснээс хойш 90 (ер) хоногийн дараа хүчингүй болно.

Энэхүү ноот бичиг болон Таны хариу ноот бичгийг хоёр орны иргэдийг визгүй зорчуулах чиглэлээр манай хоёр улсын Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээр гэж үзэх тухай саналыг гаргах завшаан тохиолдов.

Энэхүү ноот бичгийг португал, монгол, англи хэлээр үйлдэн Танд гардуулж байгаа бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Энэхүү ноот бичгийг тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

Хүндэт эрхэм Таныг гүнээ хүндэтгэн ёсолж буйг хүлээн авна уу.

Бразилиа хот. 2015 оны 9 дугаар сарын 21

Мауро Виейра,

Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын Гадаад харилцааны сайд

ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ БРАЗИЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ"

Дээрх ноот бичгийн хариуд, Монгол Улсын Засгийн газар харилцан адил байх зарчмын үндсэн дээр иргэдийг богино хугацааны визийн шаардлагаас чөлөөлөх чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэх болсныг Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс эрхэм Танд уламжлахад таатай байна:

1. Хүчин төгөлдөр зорчих бичиг баримт бүхий Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын иргэд албан хэргээр болон аялж жуулчлах зорилгоор Монгол Улсад нэг жилийн хугацаанд 90 (ер) хоногоос хэтрэхгүй хугацаанд визгүйгээр орох, гарах, дамжин өнгөрөх болон зорчих эрхтэй ба уг хугацааг Монгол Улсын нутаг дэвсгэрт анхлан нэвтрэн орсон өдрөөс эхлэн тооцно. Энэхүү 90 (ер) хоногийн хугацааг Монгол Улсын холбогдох эрх бүхий байгууллагаас нэг удаа 90 (ер) хоногоос хэтрэхгүй хугацаагаар сунгаж болно.

2. Энэхүү ноот бичигт заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор:

(1) аялж жуулчлах гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт санхүүгийн үүрэг хариуцлага хүлээхэд хүргэж болох ямар нэг ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахгүйгээр амрах, танилцах, соёлын болон бусад зорилгоор зорчихыг хэлнэ.

(2) дамжин өнгөрөх гэж Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын иргэд зорчих сүүлчийн газартаа очихын тулд Монгол Улсын нутаг дэвсгэрт нэвтрэн орох шаардлагатай болохыг хэлнэ.

(3) албан хэргээр зорчих гэж Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын иргэд Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахгүйгээр арилжаа эрхлэх боломж бололцоог судлах, уулзалт, хуралд оролцох, гэрээ байгуулах, менежментийн болон захиргааны үйл ажиллагаа явуулах зорилгоор зорчихыг хэлнэ.

3. Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын иргэд Монгол Улсын нутаг дэвсгэрт 90-ээс дээш хоногийн хугацаанд зорчих, ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах, хөдөлмөр эрхлэх, судалгаа, сургалтад оролцох, сурах, нийгмийн үйл ажиллагаанд оролцох, түүнчлэн техникийн тусалцаа үзүүлэх, томилолтоор ажиллах, шашны, эсхүл урлагийн үйл ажиллагаанд оролцох, эсхүл энэхүү ноот бичгийн 2 дахь заалтад тодорхой зааснаас бусад аливаа үйл ажиллагаа явуулах тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохих визийг урьдчилан мэдүүлэх ёстой.

4. Энэхүү ноот бичгийн 1 дэх заалтад дурдсан Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын иргэд Монгол Улсын олон улсын зорчих хөдөлгөөнд нээлттэй хилийн шалган нэвтрүүлэх цэгээр дамжин тус улсад нэвтрэн орох, дамжин өнгөрөх болон гарах эрхтэй.

5. Үүгээр олгосон визээс чөлөөлөх арга хэмжээ нь Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын иргэдийн Монгол Улсад богино хугацаагаар зорчихдоо тус

улсад хүчин төгөлдөр үйлчилж буй үндэсний хууль тогтоомжийн дагуу хүлээх үүргийг хөндөхгүй.

6. Үүгээр олгосон визээс чөлөөлөх арга хэмжээ нь Монгол Улсын Засгийн газрын Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын тааламжгүй иргэдийг өөрийн нутаг дэвсгэрт оруулахаас татгалзах болон зорчих хугацааг багасгах эрхийг хөндөхгүй.

7. Монгол Улсын Засгийн газар үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах, эсхүл олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор энэхүү ноот бичигт тодорхойлсон арга хэмжээг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь зогсоож болно. Энэхүү арга хэмжээг зогсоох тухай шийдвэрийг Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын Засгийн газарт дипломат шугамаар нэн даруй мэдэгдэнэ.

8. Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын иргэд Монгол Улсын нутаг дэвсгэрт зорчих хугацаандаа зорчих бичиг баримтаа гэж үрэгдүүлсэн тохиолдолд Монгол Улсад байгаа Бразил Улсын дипломат буюу консулын төлөөлөгчийн газраас өөр зорчих бичиг баримт авч тус улсын нутаг дэвсгэрээс гарна.

9. (1) Монгол Улсын Засгийн газар энэхүү ноот бичгийг солилцсон өдрөөс хойш 30 (гуч) хоногийн дотор Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын Засгийн газарт өөрийн паспортын загварыг өгнө.

(2) Монгол Улсын Засгийн газар өөрийн олгодог паспортод өөрчлөлт оруулсан тохиолдолд түүнийг ашиглаж эхлэхээс дор хаяж 30 (гуч) хоногийн өмнө шинэ паспортын загварыг түүнийг хэрхэн хэрэглэх тухай танилцуулгын хамт Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын Засгийн газарт хүргүүлнэ.

10. (1) Монгол Улсын Засгийн газар болон Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын Засгийн газар харилцан тохиролцож энэхүү ноот бичгийн агуулгад өөрчлөлт оруулж болох бөгөөд үүнийг дипломат шугамаар баталгаажуулж мэдэгдэнэ. Талууд өөрөөр тохиролцоогүй бол нэмэлт, өөрчлөлт нь энэхүү ноот бичгийн 11(1)-д заасны дагуу хүчин төгөлдөр болно.

(2) Энэхүү ноот бичигт тодорхойлсон арга хэмжээг тайлбарлах, эсхүл хэрэгжүүлэхтэй холбоотойгоор талуудын хооронд үүссэн маргааныг дипломат шугамаар зөвлөлдөх болон хэлэлцээ хийх замаар шийдвэрлэнэ.

11. (1) Энэхүү ноот бичигт заасан арга хэмжээ нь уг ноот бичгийг солилцсон өдрөөс хойш 30 (гуч) хоногийн дараа хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.

(2) Энэхүү ноот бичигт тодорхойлсон арга хэмжээг хугацаагүйгээр хэрэгжүүлэх бөгөөд Монгол Улсын Засгийн газар Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын Засгийн газарт дипломат шугамаар бичгээр мэдэгдэх замаар

тэдгээрийг хэдийд ч цуцалж болно. Үүгээр бий болгосон арга хэмжээ нь тэрхүү мэдэгдлийг хүргүүлснээс хойш 90 (ер) хоногийн дараа хүчингүй болно.

Таны ноот бичиг болон энэхүү хариу ноот бичгийг хамтад нь хоёр орны иргэдийг визгүй зорчуулах чиглэлээр манай хоёр улсын Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээр гэж үзэхийг нотлох завшаан тохиолдов.

Энэхүү ноот бичгийг монгол, португал, англи хэлээр үйлдэн Танд гардуулж байгаа бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Энэхүү ноот бичгийг тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

Хүндэт эрхэм Таныг гүнээ хүндэтгэн ёсолж буйг хүлээн авна уу."

Бразилиа хот, 2015 оны 9 дүгээр сарын 21

Чулуунбаатарын Сосормаа,

Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



EMBASSY OF MONGOLIA
BRASILIA

Your Excellency,

I have the honour to acknowledge receipt of your Note dated *Sept. 21*, 2015 which reads as follows:

"Your Excellency,

On behalf of the Government of the Federative Republic of Brazil I have the honour to inform you that, with a view to further developing friendly relations and strengthening close ties between our countries, safeguard the principle of reciprocity and facilitate travel for nationals of both our countries, the Government of the Federative Republic of Brazil is prepared to adopt, on the basis of reciprocal treatment, the following measures, on the issue of short-stay visa waiver:

1. The nationals of Mongolia holding valid travel documents may enter, leave, transit through and stay in the territory of the Federative Republic of Brazil without visas, for purposes of tourism or business affairs, for a period not exceeding 90 (ninety) days per year following the date of first entry into the territory of the Federative Republic of Brazil. The maximum period of 90 (ninety) days may be extended by national relevant authorities of the Federative Republic of Brazil once and for another period not exceeding 90 (ninety) days.
2. For the purpose of the measures stipulated in this Note,
 - (1) Tourism shall mean travels for recreational, informative, cultural and other purposes that shall not imply carrying out a gainful activity that may result in financial obligations to local sources in the territory of the Federative Republic of Brazil.
 - (2) Transit shall mean the need for nationals of Mongolia to enter the territory of the Federative Republic of Brazil as a condition to reach their final destination.
 - (3) Business travels shall mean travels of nationals of Mongolia, who do not carry out gainful activities in the territory of the Federative Republic of Brazil, aimed at prospecting commercial opportunities, attending meetings, signing contracts, and carrying out management and administrative activities.

3. The nationals of Mongolia must apply for the pertinent visa in accordance with the relevant national laws of the Federative Republic of Brazil in case they wish to stay in the territory of the Federative Republic of Brazil for a period longer than 90 (ninety) days, carry out gainful activities, be employed, engage in research, traineeships, studies and social work, as well as undertake technical assistance, missionary, religious or artistic activities, or carry out any activity other than those explicitly mentioned in paragraph 2 of this Note.
4. The nationals of Mongolia mentioned in paragraph 1 of this Note may enter, transit through and leave the territory of the Federative Republic of Brazil through all border-crossing points open to international traffic.
5. The visa waiver herein provided for applies without prejudice to the obligation for the nationals of Mongolia before national laws in force in the Federative Republic of Brazil during their short stay.
6. The measures herein provided for apply without prejudice to the right of the Government of the Federative Republic of Brazil to refuse entry into and to shorten the stay in its territory of unwanted nationals of Mongolia.
7. The Government of the Federative Republic of Brazil may suspend the measures herein described in whole or in part, for reasons of national security, public order or public health. The decision on suspension shall immediately be notified to the Government of Mongolia through diplomatic channels.
8. The nationals of Mongolia that lose their travel documents during their stay in the territory of the Federative Republic of Brazil must obtain another travel document issued by Mongolia's Diplomatic Mission or Consulate in Brazil in order to leave its territory.
9. (1) The Government of the Federative Republic of Brazil shall send to the Government of Mongolia through diplomatic channels specimens of its passports within 30 (thirty) days from the date of exchange of this Note.
(2) In the event of changes to the passport issued by the Government of the Federative Republic of Brazil, it shall send to the Government of Mongolia the new specimens, together with the information on their applicability, at least 30 (thirty) days before their introduction date.
10. (1) The content of this Note may be amended upon agreement between the Government of the Federative Republic of Brazil and the Government of Mongolia, followed by notification through diplomatic channels, and shall enter into force as defined in paragraph 11 (1) of this Note, unless agreed otherwise.

(2). Divergences arising from the interpretation or implementation of the measures herein described must be settled by consultations and negotiations through diplomatic channels.

11. (1) The measures provided for in this Note shall enter into force after 30 (thirty) days from the date of exchange of this Note.

(2) The measures described in this Note are stipulated for an indefinite period of time, and the Government of the Federative Republic of Brazil may terminate them at any time by giving written notice to the Government of Mongolia through diplomatic channels. The measures herein established shall cease to be in force 90 (ninety) days after the date of such notification.

I have the honour to propose that this Note and your confirmation Note in reply shall constitute a reciprocal understanding between our two Governments for the establishment of visa waiver for the nationals of both countries.

This Note is presented to Your Excellency in the Portuguese, Mongolian, and English languages, each text being equally authentic. In case of divergence in the interpretation of this Note, the English version shall be used.

Please accept, Your Excellency, the assurances of my highest consideration and esteem.

BRASILIA, *September 21*, 2015

Mauro Vieira,

Minister of External Relations of the Federative Republic of Brazil

FOR THE GOVERNMENT OF THE FEDERATIVE REPUBLIC OF BRAZIL"

In response, on behalf of the Government of Mongolia, it is my pleasure to inform Your Excellency that the Government of Mongolia is prepared to adopt, on the basis of reciprocal treatment, the following measures, on the issue of short-stay visa waiver:

1. The nationals of the Federative Republic of Brazil holding valid travel documents may enter, leave, transit through and stay in the territory of Mongolia without visas, for purposes of tourism or business affairs, for a period not exceeding 90 (ninety) days per year following the date of first entry into the territory of Mongolia. The maximum period of 90 (ninety) days may be extended by national relevant authorities of Mongolia once and for another period not exceeding 90 (ninety) days.

2. For the purpose of the measures stipulated in this Note,

- (1) Tourism shall mean travels for recreational, informative, cultural and other purposes that shall not imply carrying out a gainful activity that may result in financial obligations to local sources in the territory of Mongolia.
- (2) Transit shall mean the need for nationals of the Federative Republic of Brazil to enter the territory of Mongolia as a condition to reach their final destination.
- (3) Business travels shall mean travels of nationals of the Federative Republic of Brazil, who do not carry out gainful activities in the territory of Mongolia, aimed at prospecting commercial opportunities, attending meetings, signing contracts, and carrying out management and administrative activities.
3. The nationals of the Federative Republic of Brazil must apply for the pertinent visa in accordance with the relevant national laws of Mongolia in case they wish to stay in the territory of Mongolia for a period longer than 90 (ninety) days, carry out gainful activities, be employed, engage in research, traineeships, studies and social work, as well as undertake technical assistance, missionary, religious or artistic activities, or carry out any activity other than those explicitly mentioned in paragraph 2 of this Note.
4. The nationals of the Federative Republic of Brazil mentioned in paragraph 1 of this Note may enter, transit through and leave the territory of Mongolia through all border-crossing points open to international traffic.
5. The visa waiver herein provided for applies without prejudice to the obligation for the nationals of the Federative Republic of Brazil before national laws in force in Mongolia during their short stay.
6. The measures herein provided for applies without prejudice to the right of the Government of Mongolia to refuse entry into and to shorten the stay in its territory of unwanted nationals of the Federative Republic of Brazil.
7. The Government of Mongolia may suspend the measures herein described in whole or in part, for reasons of national security, public order or public health. The decision on suspension shall immediately be notified to the Government of the Federative Republic of Brazil through diplomatic channels.
8. The nationals of the Federative Republic of Brazil that lose their travel documents during their stay in the territory of Mongolia must obtain another travel document issued by Brazil's Diplomatic Mission or Consulate in Mongolia in order to leave its territory.
9. (1) The Government of Mongolia shall send to the Government of the Federative Republic of Brazil through diplomatic channels specimens of its passports within 30 (thirty) days from the date of exchange of this Note.

(2) In the event of changes to the passport issued by the Government of Mongolia, it shall send to the Government of the Federative Republic of Brazil the new specimens, together with the information on their applicability, at least 30 (thirty) days before their introduction date.

10. (1) The content of this Note may be amended upon agreement between the Government of Mongolia and the Government of the Federative Republic of Brazil, followed by notification through diplomatic channels, and shall enter into force as defined in paragraph 11 (1) of this Note, unless agreed otherwise.

(2). Divergences arising from the interpretation or implementation of the measures herein described must be settled by consultations and negotiations through diplomatic channels.

11. (1) The measures provided for in this Note shall enter into force after 30 (thirty) days from the date of exchange of this Note.

(2) The measures described in this Note are stipulated for an indefinite period of time, and the Government of Mongolia may terminate them at any time by giving written notice to the Government of the Federative Republic of Brazil through diplomatic channels. The measures herein established shall cease to be in force 90 (ninety) days after the date of such notification.

I have the honour to confirm that Your note and this reply Note shall together constitute a reciprocal understanding between our two Governments for the establishment of visa waiver for the nationals of both countries.

This Note is presented to Your Excellency in the Mongolian, Portuguese and English languages, each text being equally authentic. In case of divergence in the interpretation of this Note, the English version shall prevail.

Please accept, Your Excellency, the assurances of my highest consideration and esteem.

BRASILIA, *September 21*, 2015

Chuluunbaatar Sosormaa,



Ambassador Extraordinary and Plenipotentiary of Mongolia
to the Federative Republic of Brazil

FOR THE GOVERNMENT OF MONGOLIA